



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг холбогдох байгууллагад хүргүүлж мөрдүүлэх, хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн дарга /С.Магнайсүрэн/-д даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын “Дүрэм шинэчлэн батлах тухай” 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 218 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Б.МӨНХБААТАР

151030579

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн
211... дугаар тушаалын хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛАЛД ХАМААРАХ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛЫГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг тогтоосноор барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, барилгын ажлын зөвшөөрөл олгох, барилга байгууламжийг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах, барилгын салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох, сунгах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, барилгын ажилд захиалагчийн хяналт тавих зэрэг үйл ажиллагааг зохицуулах үндэслэл болно.

1.2. Барилгын тухай хуулийн 10.1-д заасан барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг барилга байгууламжийн норматив баримт бичигт тусгагдсан (хариуцлагын болон галын зэрэглэл, үндсэн бүтээцийн материал, техник-эдийн засгийн үзүүлэлт, онцгой байдлын нөхцөлд үүсэж болзошгүй эдийн засаг-нийгмийн болон байгаль орчны үр дагавар) төлөвлөлт тооцооны үзүүлэлтүүдийг харгалзан Барилгын тухай хуулийн 9.1-д заасан барилгын ажлын төрөлтэй уялдуулан тогтооход оршино.

Хоёр. Хэрэглэх хүрээ

2.1. Энэхүү дүрмээр Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д заасан барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан барилгын ажлын төрөлтэй уялдуулж, тогтооно.

2.2. Одоо ашиглагдаж байгаа барилга байгууламжийн буулгалтын ажлын төвөгшлийн ангилалд хамаарах барилга байгууламжийг тодорхойлоход мөн адил хэрэглэнэ.

Гурав. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилал

3.1. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг энэ журмын нэгдүгээр хавсралтад зааснаар тогтооно.

3.2. Энэ журмын нэгдүгээр хавсралтад дурдсанаас бусад (инженер геологийн онцгой нөхцөлд баригдах) цамхаг, тулгуур, түшиц хана зэрэг 30 метрээс дээш өндөр, 60 метрээс дээш алгасалтай байгууламж, 16-аас дээш давхартай барилга, ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэр, бохир ус цэвэрлэх барилга байгууламжийг төвөгшлийн "онцгой" ангилалд хамаарна.

3.3. Энэ журмын нэгдүгээр хавсралтад болон 3.2-т дурдагдаагүй барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг энэ журмын хоёрдугаар хавсралтад дурдсан аргачлалын дагуу тогтооно.

3.4. Аргачлалын дагуу тодорхойлсон барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг барилгын доуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага нь тухайн чиглэлийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тогтооно.

3.5. Барилга байгууламжийн инженер хайгуулын судалгаа болон барилгын дотор инженерийн хангамжийн системийн төвөгшлийн ангилал нь тухайн барилга байгууламжийн ангилалтай адил байна.

3.6. Инженерийн дэд бүтцийн төвөгшлийн ангилал нь техникийн шинж чанарын үзүүлэлтээс (гаднах барилгын төвөгшлийн ангилалаас үл хамаарна. Жишээ нь: УДДТ, ЦДТ, ШТС гэх мэт) хамаарна.

Дөрөв. Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд өөрчлөлт оруулах

4.1. Барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал, төлөвлөлт, техникийн шинж чанарыг өөрчлөлгүйгээр засварлаж, шинэчлэлт хийсэн барилга байгууламжийн төвөгшлийн ангилал хэвээр байна.

4.2. Барилга байгууламжийн ашиглалтын хэвийн нөхцлийг хангах зорилгоор барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал зэрэг техникийн шинж чанарыг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчилж засварласан, өргөтгөл шинэчилэлт хийсэн бол тухайн барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд өөрчлөлт оруулах үндэслэл болно.

4.3. Барилга байгууламжийг засварлах, тоноглох (хүчитгэх, бэхлэх, сэргээн засах) барилгын ажлын төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн барилгад паспоржуулалт хийсэн мэргэжлийн дүгнэлт, мөн орон тооны бус паспортжуулалтын зөвлөл, тухайн чиглэлийн мэргэжлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн баталгаажуулна.

4.3. Барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх үед тухайн барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг нэгдүгээр хавсралтад дурьдсан барилга байгууламжийн төвөгшилтэй дүйцүүлэн тодорхойлох ба харин тус нэгдүгээр хавсралтын ангилалд заасан тухайн барилга байгууламжийн хэмжээг дараагийн ангилалд хамаарахаар нэмэгдүүлж буй тохиолдолд төвөгшлийн ангилалыг ахиулж тооцно.

4.4. Олгогдсон барилгын талбайд нэгээс дээш ангилалын нэг зэрэгт хамаарах барилгын ажил гүйцэтгэвэл ангилалыг нэмэгдүүлэх ба олон ангилалын барилгын ажил гүйцэтгэх тохиолдолд тухайн барилга байгууламжуудын хамгийн их төвөгшлийн зэргээр тооцно.

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журмын нэгдүгээр хавсралт

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах барилга байгууламжийн зориулалт, хүчин чадал

Барилга байгууламжийн ангилал				
1	2	3	4	5
Зориулалт, хүчин чадал	Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж	Дунд төвөгшилтэй барилга байгууламж	Өндөр төвөгшилтэй барилга байгууламж	Онцгой төвөгшилтэй барилга байгууламж
	<p>2.1. 9-16 м өндөртэй 5 хүртэл давхар олон айлын болон блокчилсон орон сууцны барилга</p> <p>2.2. 9-16 м өндөртэй, 5 хүртэл давхар олон нийтийн зориулалттай барилгууд</p> <p>2.3. Хүн олноор нэгэн зэрэг цуглах 24 м хүртэл алгасалттай барилга байгууламж (задгай болон битүү байгууламж)</p>	<p>3.1. 16-30 м өндөртэй 5-9 давхар олон давхар орон сууцны барилга</p> <p>3.2. Хүн олноор нэгэн зэрэг цуглах 24-36 м хүртэл алгасалттай барилга байгууламж (задгай болон битүү байгууламж)</p>	<p>4.1. 30-51 м өндөртэй 9-16 давхар орон сууцны өндөр барилга</p> <p>4.2. 30-50 м өндөртэй 9-16 давхар орон сууцнаас бусад зориулалттай өндөр барилгууд</p> <p>4.3. Хүн олноор нэгэн зэрэг цуглах 36-60 м алгасалттай барилга байгууламж (задгай болон битүү байгууламж)</p>	<p>5.1. 51 метрээс дээш өндөртэй 16 давхраас дээш орон сууцны өндөр барилга</p> <p>5.2. 51 метрээс дээш өндөртэй 16 давхраас дээш орон сууцнаас бусад зориулалттай өндөр барилгууд</p> <p>5.3. Хүн олноор нэгэн зэрэг цуглах 60 м-ээс дээш алгасалттай барилга байгууламж (задгай болон битүү байгууламж)</p> <p>5.4. Тусгай нөхцөл, техникийн даалгавар шаардагдах онцгой зориулалттай барилга байгууламж (засгийн газрын ордон, телевиз, батлан хамгаалах зориулалттай барилга байгууламжууд гэх мэт)</p>
Олон нийтийн	Төрөл бүрийн зориулалттай олон нийтийн барилга			

Эрүүл мэндийн		2.4. Анхан шатны эмнэлгийн барилга	3.3. Эмнэлэг, үзлэгийн байрны цогцолбор барилга 3.4. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн байрны барилга	4.4. 100 ба түүнээс дээш ортой нэгдсэн эмнэлэг буюу түүнтэй адил эмнэлэг 4.5. Халдварт өвчин судлалын төв, цус бэлтгэх төв, зоонозын өвчин судлалын төв гэх мэт тусгай нөхцөл шаардах барилгууд	-
Түүх соёлын			3.5. Өндөр төвөгшилтэй барилгад хамаарахгүй музей, үзэсгэлэнгийн барилга 3.6. Өндөр төвөгшилтэй барилгад хамаарахгүй сум, хийдийн барилга	4.6. Түүх соёлын үл хөдлөх дурсгалт барилга байгууламж (ОУ-ын болон МУ-ын соёлын өв санд бүртгэлтэй)	-
Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга					
Сургуулийн өмнөх			3.7. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилга		-
Сургалт, боловсролын байгууллага			3.8. Сургуулийн хичээлийн байрны барилга /цогцолбор/ 3.9. Тусгай хэрэгцээт болон Үйлдвэр сургалтын хичээлийн барилга байгууламж /цогцолбор/ 3.10. Хүүхэд хамгаалах төв	4.7. Их дээд сургуулийн хичээлийн байрны барилга /цогцолбор/	-
Үйлдвэрийн барилга байгууламж					
Үйлдвэр		2.5. 24 м хүртэл алгасалттай үйлдвэрийн барилга байгууламж /цогцолбороор/	3.11. 24-36 м хүртэл алгасалттай үйлдвэрийн барилга байгууламж /цогцолбороор/	4.8. 36-60 м хүртэл алгасалттай үйлдвэрийн байгууламж барилга /цогцолбороор/	5.5. 60 м-ээс дээш алгасалттай үйлдвэрийн байгууламж /цогцолбороор/

	1.2. Хоногт 5 тн хүртэл тэжээл, эрдэс бордоо үйлдвэрлэх үйлдвэр	2.6. Хоногт 5 тн-оос дээш хүртэл тэжээл, эрдэс бордоо үйлдвэрлэх үйлдвэр	3.12. Тусгай параметрууд шаардагдах хөргөлтийн систем бүхий барилга байгууламж	4.9. Өндөр температурын боловсруулалттай химийн болон бусад үйлдвэрлэлийн зориулалттай үйлдвэрийн барилга байгууламж	5.6. Уул уурхайн ашиглах болон боловсруулах үйлдвэрийн барилга байгууламж 5.7. Химийн хорт болон аюултай бодис үйлдвэрлэлийн барилга байгууламж 5.8. Химийн үйлдвэрлэлийн барилга байгууламж
Агуулахын барилга байгууламж					
	2.7. 24 м хүртэл алгаслалтай агуулахын барилга байгууламж	3.13. 24-36 м хүртэл алгаслалтай агуулахын барилга байгууламж	3.14. Үйлдвэрлэлийн дэргэдэх бүх төрлийн хөргөлттэй агуулахын хөргөлтийн байгууламж	4.10. 36-60 м хүртэл алгаслалтай агуулахын барилга байгууламж 4.11. Тэсэрч дэлбэрэх, тэсэлгээний бодис, химийн хорт болон аюултай бодис хэрэглэх, хадгалах барилга байгууламж	5.9. 60 м-ээс дээш алгаслалтай бүрийн зориулалттай агуулахын барилга байгууламж
Авто машины зогсоол					
Зогсоол	2.8. Зоорьгүй, нэг давхар, машин тус бүр тусдаа бокстой 30 хүртэл автомашины зогсоолын барилга	3.15. 30-60 хүртэл автомашины 36 м хүртэл алгаслалтай битүү зогсоолын барилга	3.16. 24-48 хүртэл автомашины автомат битүү зогсоолын байгууламж	4.12. 60-100 хүртэл автомашины 36-60 м хүртэл алгаслалтай битүү зогсоолын барилга	5.10. 100-аас дээш автомашины 60 м-ээс дээш алгаслалтай битүү зогсоолын барилга
Автомат зогсоолын байгууламж	2.9. 24 хүртэл автомашины автомат зогсоолын байгууламж	3.16. 24-48 хүртэл автомашины автомат битүү зогсоолын байгууламж	3.16. 24-48 хүртэл автомашины зогсоолын битүү зогсоолын байгууламж	4.13. 48-100 хүртэл автомашины автомат битүү зогсоолын байгууламж	
Эрчим хүчний эх үүсвэр					
Эрчим хүчний эх үүсвэр	2.10. 1 МВт хүртэлх хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	3.17. 1-5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	3.17. 1-5 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	4.14. 5-30 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр	5.11. 30 МВт ба түүнээс дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр
Дулааны сүлжээ, түүний барилга байгууламж					

Дулаан хуваарих төв		<p>2.11. 15 МВт хүртэл хүчин чадалтай 115°C хүртэл температуртай ус усны, 0.07 МПа хүртэл даралттай уур усны дулаан солилцуулагчтай дулаан хуваарилах төв</p> <p>2.12. 115°C хүртэл температуртай халуун ус, 0.07 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам</p>	<p>3.18. 15 МВт хүртэл хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус усны, 3.9 МПа хүртэл даралттай уур усны дулаан солилцуулагчтай Хэрэглэгч дулаан хуваарилах төв хоёрын байршлын өндрийн зөрүү нь 51 м-ээс ихгүй дулаан хуваарилах төв</p> <p>3.19. Ду < 500 мм голчтой 200°C хүртэл температуртай халуун ус, 3.9 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам</p>	<p>4.15. 15 МВт ба түүнээс дээш хүчин чадалтай 200°C хүртэл температуртай ус усны, 3.9 МПа-аас их даралттай уур усны дулаан солилцуулагчтай, Хэрэглэгч дулаан хуваарилах төв хоёрын байршлын өндрийн зөрүү нь 51 м-ээс их дулаан хуваарилах төв</p> <p>4.16. Ду ≥ 500 мм буюу түүнээс дээш голчтой 200°C хүртэл температуртай халуун ус, 3.9 МПа хүртэл даралттай уур дамжуулах шугам</p>	<p>5.12. 200°C-аас их температуртай ус усны, 3.9 МПа-аас их даралттай уур усны дулаан солилцуулагчтай дулаан хуваарилах төв</p> <p>5.13. 200°C-аас их температуртай халуун ус, 3.9 МПа-аас их даралттай уур дамжуулах шугам</p>
Дулааны сүлжээ					
Цахилгааны шугам сүлжээ		<p>Цахилгаан хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ, хуваарилах байгууламж</p> <p>2.13. 0.4-10 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан шугам сүлжээ</p>	<p>3.20. 10 кВ болон түүнээс дээш 35 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан шугам сүлжээ</p>	<p>4.17. 35 кВ ба түүнээс дээш 220 кВ хүртэл хүчдэлтэй цахилгаан шугам сүлжээ</p>	<p>5.14. 220 кВ ба түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан шугам сүлжээ</p>
Ус хангамж, ариутгах татурсга		<p>2.14. Бага төвөгшилтэй барилгын гадна ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ</p>	<p>3.21. 150.0 м³/хон хүртэл хүчин чадалтай ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах болон салбар шугам сүлжээ</p> <p>3.22. 150.0 м³/хон хүртэл хүчин чадалтай ахуйн бохир усны цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын дамжуулах болон салбар шугам сүлжээ</p>	<p>4.18. 150 м³/хон-оос дээш хүчин чадалтай ус хангамжийн эх үүсвэр, дамжуулах шугам сүлжээ</p> <p>4.19. Нийслэл, бүсийн тулгуур төв, хот, бус нутгийн түвшний ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж</p>	<p>5.15. Инженер-геологийн онцгой хүндрэлтэй нөхцөлд баригдах ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламж</p> <p>5.16. Шинэ дэвшилтэт технологийг турших нарийн технологи болон барилгын хийцтэй ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж</p>

<p>Бохир ус цэвэрлэх байгууламж</p>		<p>3.23. 50 м³/хон хүртэл хүчин чадалтай найрлагаараа ахуйн бохир устай төстэй үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламж</p>	<p>4.20. 150 м³/хон-оос дээш хүчин чадалтай ахуйн бохир усны цэвэрлэх байгууламж болон ариутгах татуургын дамжуулах шугам сүлжээ,</p> <p>4.21. 50.0 м³/хон-оос дээш хүчин чадалтай үйлдвэрийн бохир усны цэвэрлэх байгууламж (найрлага нь химийн болон хүнд металлийн бохирдолтой)</p>	
<p>Усны барилга байгууламж</p>				
<p>1.3. Инженерийн бус буюу энгийн хийцтэй, түр усны барилга байгууламж</p>	<p>2.15. Инженерийн усны бага барилга байгууламж, II зэрэглэлийн IV ангийн барилга</p>	<p>3.24. Усны барилга байгууламжууд III-IV ангийн байнгын үндсэн байгууламжууд</p>	<p>4.22. Усны барилга байгууламжууд II ангийн байнгын үндсэн байгууламжууд</p>	<p>5.17. Усны барилга байгууламжуудын I ангийн байнгын, үндсэн байгууламжууд</p>
<p>Мэдээлэл, холбоо-сүлжээний барилга байгууламж</p>				
<p>2.16. Авто зам, гудамж талбайн дохиолол, хамгаалалт, хяналтын системийн барилга байгууламж, нийтийг хамарсан зарлан мэдээлэх системийн байгууламж</p>	<p>3.25. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн бага, дунд хүчин чадалтай барилга байгууламж, үүрэн холбооны бааз станцын байгууламжууд</p>	<p>4.22. Харилцаа холбооны үйлчлэгчийн техникийн төвийн барилга байгууламж.</p> <p>4.23. Улс, хот хоорондын чанартай харилцаа холбооны үндсэн шугам сүлжээ.</p> <p>4.24. Мэдээллийн сан (дата) төвийн барилга байгууламж.</p>	<p>5.18. Олон улсын хэмжээний төсөл, хөтөлбөрөөр хэрэгжих харилцаа холбооны цогц шийдэл бүхий томоохон хэмжээний цогцолбор барилга байгууламж, мэдээлэл холбооны шугам сүлжээ</p>	
<p>Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн барилга байгууламж</p>				
<p>3.27. Шатахуун, хий цэнэглэх станцын барилга байгууламж, түүний дагалдах үйлчилгээний барилга (худалдаа, хоолны газар, амрах буудал, техник үйлчилгээ, машин угаалгын газар, харуул хамгаалалттай зогсоол г/м)</p>	<p>4.25. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн хийн бүх төрлийн агуулах, шилжүүлэн ачих байгууламж</p> <p>4.26. Газрын тос ба хийн цооногийн байгууламж</p> <p>4.27. Газрын тос, хийн орд газрын дэргэдэх газрын тос, хий, ус цуглуулах, тээвэрлэх объектын барилга байгууламж</p>	<p>5.19. Газрын тос, хий боловсруулах үйлдвэрийн барилга байгууламжууд</p> <p>5.20. Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн, хийн төв дамжуулах хоолой, холбогдох барилга байгууламжууд</p>		

			<p>3.28. Авто машиныг шатахуун болон хийгээр цэнэглэх станцын барилга байгууламж, түүний дагалдах үйлчилгээний барилга (худалдаа, хоолны газар, амрах буудал, техник үйлчилгээ, машин угаалгын газар, харуул хамгаалалттай зогсоол т/м)</p> <p>3.29. Газрын тосны бүтээгдэхүүн, шахсан болон шингэрүүлсэн хий борлуулах цэг, баллон хадгалах агуулах, хэрэглэгчийн хийн тоног төхөөрөмж, шугам сүлжээ</p>	<p>4.28. Газрын тос ба хийн цооногийн байгууламж болон түүний дэргэдэх газрын тос, хий, ачиж, буулгах, тээвэрлэх объектын барилга байгууламж</p> <p>4.29. Нисэх онгоцыг түлшээр цэнэглэх зориулалт бүхий нисэх буудлын талбай дахь далд шугам хоолойн байгууламж, тоног төхөөрөмж</p> <p>4.30. Далд уурхайн газрын гүнд ашиглагдах газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн шатаг хий хадгалах, түгээх, дамжуулах барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээ</p>	<p>5.21. Газрын тосны орд газрын дэргэдэх газрын тос, хий, ус цуглуулах, хадгалах, тээвэрлэх объектын барилга байгууламж</p> <p>5.22. Нүүрснээс шингэн түлш болон шатаг хий боловсруулах үйлдвэр, барилга байгууламж, тоног төхөөрөмж, дамжуулах төв шугам хоолой</p>
			Хөдөө аж ахуйн зориулалттай барилга байгууламж		
<i>Хүнс, тариалан</i>	<p>2.17. Үр тариа хатаах цэвэрлэх, хатаах байгууламж</p> <p>2.18. 1 га-аас илүү талбайтай хүлэмжний аж ахуйн байгууламж</p> <p>2.19. 1000 толгой хүртэл хүчин чадалтай үхрийн аж ахуй, төл бойжуулах, тэжээх барилга байгууламж</p> <p>2.20. 500 толгой хүртэлх хүчин чадалтай гахайн аж ахуйн барилга байгууламж</p>				
	<p>3.31. 1000 толгойгоос дээш хүчин чадалтай үхрийн аж ахуй, төл бойжуулах, тэжээх барилга байгууламж</p> <p>3.32. 500 толгойгоос дээш хүчин чадалтай гахайн аж ахуйн барилга байгууламж</p>				
<i>Мал аж ахуй</i>					

		<p>2.21. 300 мянга хүртэл толгой шувууны өндөгний аж ахуй, 6 сая хүртэл тахианы махны аж ахуй, 1 мянга хүртэл шувууны аж ахуйн барилга байгууламж</p> <p>2.22. Сүү үйлдвэрлэлийн чиглэлийн мал аж ахуйн цогцолборын барилга байгууламж;</p>			
Цамхаг, тулгуур, түшиц хана түүнтэй адил байгууламж					
		<p>2.23. 12 м хүртэл өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p>	<p>3.33. 12-21 м хүртэл өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p>	<p>4.31. 21-30 м хүртэл өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p>	<p>5.23. 30 м-ээс дээш өндөртэй цамхаг, тулгуур, түшиц хана болон түүнтэй адил байгууламж</p>
Тур барилга байгууламж					
	<p>1.4. Тур барилга байгууламж Барилгын ажил зохион байгуулах, гүйцэтгэх, барилга барьж байгаа байгууллагын ажиллагсдад үйлчлэх ашиглаж байгаа (үйлдвэрлэлийн болон туслах) барилга байгууламжууд</p> <p>1.5. Зөөврийн болон туслах барилга байгууламж</p>	<p>2.24. 150-аас дээш хүн тур байрлах байр /36 сараас дээш хугацаагаар байрлах 9 метрээс дээш өндөртэй/</p>			

Бусад

Зам тээврийн барилга байгууламж	-	-	-	-	<p>5.24. Метроны барилга байгууламж</p> <p>5.25. Нисэх онгоцны барилга буудлын байгууламж</p> <p>5.26. Төмөр зам, түүний барилга, байгууламж, төмөр замын туннель</p> <p>5.27. Туннелийн байгууламж</p>
Эрчим хүчний барилга	-	-	-	-	<p>5.28. Цөмийн эрчим хүчний барилга байгууламж</p>

Тайлбар:

- Барилгын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 30 дугаар зүйлийн 32.1.5 -д заасан барилга байгууламжууд онцгой төвөгшилд хамаарна.
- Барилгын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д хамаарах барилга байгууламжийн бие даасан ус болон дулаан хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамжийн шугам сүлжээ нь тус ангилалд хамаарна.
- Бүх төрлын өргөх байгууламж, лифт, эскалатор зэргийг шинэчлэх тохиолдолд тухайн барилга байгууламжийн төвөгшилтэй адил байна.
- Барилга байгууламжийн буулгалтын ажлын төвөгшил нь тухайн барилгын төвөгшилтэй адил байна.

Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журмын хоёрдугаар хавсралт

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТӨВӨГШЛИЙН АНГИЛАЛД ХАМААРАХ ЗОРИУЛАЛТ, ХҮЧИН ЧАДЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Тодорхойлох шалгуур

1.1. “Барилга байгууламжийн төвөгшлийн ангилалд хамаарах зориулалт, хүчин чадлыг тогтоох журам”-ын нэгдүгээр хавсралт болон 3.2-т дурдагдаагүй барилга байгууламжийн зориулалт, хүчин чадлыг тодорхойлохдоо дор дурьдсан шалгууруудыг харгалзан үзнэ. Үүнд:

- 1.1.1. Барилга байгууламжийн зориулалт, эзэлхүүн төлөвлөлт;
- 1.1.2. Барилга байгууламжийн галын түймрийн эрсдлийн зэрэг;
- 1.1.3. Барилга байгууламжийн хариуцлагын зэрэглэл;
- 1.1.4. Барилга байгууламжийн үндсэн бүтээц, хийцийн төрөл;
- 1.1.5. Барилга байгууламжийн инженерийн хангамж технологи;
- 1.1.6. Нийгэм, эрүүл ахуй, байгаль орчинд нөлөөлөх үзүүлэлт.

Хоёр. Шалгуур үзүүлэлт ба түүнийг үнэлэх оноо

2.1. Барилга, байгууламжийг төвөгшлийн аль ангилалд хамаарах эсэхийг тогтоохдоо шалгуур бүрт харгалзах оноог өгч үнэлнэ. Тухайн үнэлж буй барилга, байгууламжийн үзүүлэлт тус бүрт өгөгдөх онооны нийлбэр нь 40-100 хүртэл байна. Шалгуур, үзүүлэлтийг үнэлсэн үнэлгээний нийлбэр оноо нь барилга, байгууламжийг аль төвөгшлийн ангилалд (Хүснэгт 1) хамаарахийг тодорхойлно.

Хүснэгт 1. Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилал

	Төвөгшлийн ангилал	Шалгуур, үзүүлэлтийн үнэлгээний нийт оноо
1	Барилгын ажлын зөвшөөрөл шаардахгүй барилга байгууламж	40 хүртэл
2	Бага төвөгшилтэй барилга байгууламж	41-59
3	Дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламж	60-79
4	Өндөр төвөгшилтэй барилга байгууламж	80-89
5	Онцгой төвөгшилтэй барилга байгууламж	90-100

2.3. Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилалыг доорх хүснэгтийн (Хүснэгт 2) дагуу тодорхойлно.

Хүснэгт 2. Барилга, байгууламжийг тодорхойлох шалгуур, үзүүлэлт

Шалгуур	Үзүүлэлт	Тодорхойлох үзүүлэлт		Оноо	Тайлбар
Шалгуур 1	Барилга байгууламжийн зориулалт, төлөвлөлт	орон сууц	51-ээс дээш метр	25	
			16-50 м хүртэл	20	
			15 м хүртэл	15	
		олон нийт	60-аас дээш хүн цуглах	25	
			59 хүртэл хүн цуглах	20	
			20 хүртэл хүн цуглах	15	
		Үйлд вэр	хүнд	25	
			хөнгөн	20	
			бусад	15	
Шалгуур 2	Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын зэрэглэл	онц аюултай		25	Монгол Улсын Шадар сайдын 2017 оны "Барилга байгууламжийн гал түймрийн эрсдлийн зэргийн ангилал" батлах тухай 61 дүгээр тушаалын хүрээнд тодорхойлно.
		I зэрэг		20	
		II зэрэг		15	
		III зэрэг		5	
Шалгуур 3	Барилга байгууламжийн хариуцлагын зэрэглэл	1		20	Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага" /БНБД 20-01-11/-ийн 9 дүгээр бүлэгт тусгагдсаны дагуу тодорхойлно.
		2		15	
		3		10	
		4		5	
Шалгуур 4	Барилга байгууламжийн бүтээц, хийцийн төрөл	Төмөр бетон		10	Барилга байгууламж нь хосолмол бүтээцтэй бол аль өндөр оноотой бүтээц, хийцийн төрлийг сонгож оноо өгнө.
		Угсармал бүтээц		10	
		Модон бүтээц		8	
		Ган бүтээц		8	
		Өрөгт бүтээц		6	
Шалгуур 5	Барилга байгууламжийн инженерийн хангамж технологи	шинэ технологи		10	
		уламжлалт		5	
Шалгуур 6	Нийгэм, эрүүл ахуй, байгаль орчинд нөлөөлөх үзүүлэлт	өндөр		10	
		дунд		8	
		бага		6	

Гурав. Шалгуур, үзүүлэлтийг баталгаажуулах

3.1. Тухайн чиглэлийн мэргэжлийн зөвлөлийн гишүүн тус бүрийн үнэлсэн онооны дунджаар үнэлгээний нийт оноог гаргаж аль төвөгшлийн ангилалд хамаарахыг тогтооно. (А Хавсралт).

3.2. Төвөгшлийн ангилалыг нь тогтоосон дүгнэлтийг (В Хавсралт) барилга, байгууламжийн баримт бичигт хавсаргана.

----- оОо-----

Барилга, байгууламжийг тодорхойлох үнэлгээний хуудас (Загвар)

Шалгуур	Үзүүлэлт	Тодорхойлох үзүүлэлт		Оноо	Дүгнэсэн оноо	Тэмдэглэл
Шалгуур 1.	Барилга байгууламжийн зориулалт, эзэлхүүн төлөвлөлт	орон сууц	51-ээс дээш метр	25		
			16-50 м хүртэл	20		
			15 м хүртэл	15		
		олон нийт	60-аас дээш хүн цуглах	25		
			59 хүртэл хүн цуглах	20		
			20 хүртэл хүн цуглах	15		
		үйлдвэр	хүнд	25		
			хөнгөн	20		
			бусад	15		
Шалгуур 2.	Барилга байгууламжийн галын аюулгүй байдлын зэрэглэл	онц аюултай		25		
		I зэрэг		20		
		II зэрэг		15		
		III зэрэг		5		
Шалгуур 3.	Барилга байгууламжийн хариуцлагын зэрэглэл	1		20		
		2		15		
		3		10		
		4		5		
Шалгуур 4.	Барилга байгууламжийн бүтээц, хийцийн төрөл	Төмөр бетон		10		
		Угсармал бүтээц		10		
		Модон бүтээц		8		
		Ган бүтээц		8		
		Өрөгт бүтээц		6		
Шалгуур 5.	Барилга байгууламжийн инженерийн хангамж технологи	шинэ технологи		10		
		уламжлалт		5		
Шалгуур 6.	Нийгэм, эрүүл ахуй, байгаль орчинд нөлөөлөх үзүүлэлт	өндөр		10		
		дунд		8		
		бага		6		

Барилга, байгууламжийн төвөгшлийн ангилал тогтоосон дүгнэлт

1. Улс:	2. Аймаг:	3. Сум, дүүрэг:
4. Барилга байгууламжийн нэр:		5. Хаяг
6. Барилга байгууламжийн зориулалт, эзэлхүүн төлөвлөлт:		
7. Бүтээц, хийцийн төрөл:		
8. Галын аюулгүй байдлын зэрэглэл:		
9. Барилга байгууламжийн хариуцлагын зэрэглэл:		
10. Холбогдох баримт бичиг, материал/эх сурвалж:		
11. Шаардлагатай бусад мэдээлэл:		
12. Аль төвөгшлийн ангилалд хамаарагдах:		
13. Баталгаажуулсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох газрын дарга: (Овог нэр)		14. Огноо